УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2019 оны 02 сарын 15 өдөр Дугаар А/37 Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дэх заалт, 3 дугаар хэсгийн 3.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын үер, усны аюулаас урьдчилан сэргийлэх, ус зайлуулах барилга байгууламжийн хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах, инженерийн шугам сүлжээний ашиглалтын нөхцөл байдал, холбогдох журмын хэрэгжилт үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгч, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах, зөвлөмж гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга	Т.Хэрлэн	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн дарга
Гишүүд	П.Чойжилжав	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит, дотоот хяналтын хэлтсийн Дотоод хяналтын мэргэжилтэн
	Ц.Гантулга	Нийслэлийн Онцгой байдлын газрын Гамшгийн шуурхай удирдлагын хэлтсийн мэргэжилтэн, Ахмад
	Ц.Буянхишиг	Нийслэлийн Хот төлөвлөлт, Ерөнхий төлөвлөгөөний газрын Инженерийн дэд бүтцийн төлөвлөлтийн хэлтсийн инженер-
	Л.Батбаяр	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Дэд бүтцийн хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын Ахлах байцаагч
	А.Цэцэгмаа	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Дэд бүтцийн хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын Ахлах байцаагч

D:\backup_old_pc\Work documents\doc 2019\Тушаал doc.docx

- 1119300137

Д.Дэлгэрмаа	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын Дэд бүтцийн хяналтын хэлтсийн Барилгын техникийн хяналтын улсын Ахлах байцаагч
Г.Ганзориг	"Улаанбаатар хотын Шуурхай удирдлага зохицуулалтын төв" ОНӨААТҮГ-ын Ерөнхий диспетчер
Д.Дашдаваа	Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын Зам барилгын хяналтын хэлтсийн мэргэжилтэн
Б.Ертис	Нийслэлийн Авто замын хөгжлийн газрын Бодлого зохицуулалтын хэлтсийн мэргэжилтэн
С.Батсайхан	"Геодези, Усны барилга байгууламжийн газар" ОНӨААТҮГ-ын Ерөнхий инженер
Н.Сайнбаяр	"Геодези, Усны барилга байгууламжийн газар" ОНӨААТҮГ-ын Засвар, ашиглалтын албаны дарга
	Төвийн 6 дүүргийн Газрын алба, Онцгой байдлын хэлтсийн Гамшгийн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн, Дэд бүтцийн хэлтсийн асуудал хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга М.Балдандорж	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн Ус зайлуулах барилга байгууламжийн асуудал хариуцсан мэргэжилтэн

2. Ажлын хэсгийн ажиллах "Хаврын шар усны үерээс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд үерийн далан суваг, ус зайлуулах шугам сүлжээнд үзлэг шалгалт зохион байгуулах ажил"-ын удирдамжийг хавсралт ёсоор баталсугай.

3. Ус зайлуулах шугам сүлжээнд үзлэг шалгалт явуулах ажлыг батлагдсан удирдамжийн дагуу ажлын гүйцэтгэл, үр дүн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг 2019 оны 03 дугаар сарын 04-ний дотор Хотын Ерөнхий менежерт танилцуулан ажиллахыг Ажлын хэсэг /Т.Хэрлэн/-т үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА Ч.ГАНТӨМӨР

D:\backup_old_pc\Work documents\doc 2019\Тушаал doc.docx

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 02 дугаар сарын 15
өдрийн А/34 тушаалын хавсралт

ХАВРЫН ШАР УСНЫ ҮЕРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД ҮЕРИЙН ДАЛАН СУВАГ, УС ЗАЙЛУУЛАХ ШУГАМ СҮЛЖЭЭНД ҮЗЛЭГ ШАЛГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Улаанбаатар хотын хаврын шар усны үерээс урьдчилан сэргийлэх, ус зайлуулах барилга байгууламжийн хэвийн найдвартай үйл ажиллагааг хангаж ус нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах,

Хоёр. Үзлэг хийх хугацаа ба хамрагдах барилгууд.

Үзлэг, шалгалтыг 2019 оны 02 дугаар сарын 15-аас 2019 оны 03 дугаар сарын 04-ний хооронд Нийслэлийн нутаг дэвсгэрт байршилтай үерийн хамгаалалтын барилга байгууламж, далан сувгийн дагуух барилга байгууламжид явуулна.

Гурав. Үзлэг шалгалтын бүрэлдэхүүн.

- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтэс
- Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Аудит, дотоод хяналтын хэлтэс
- Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар
- Нийслэлийн Хот төлөвлөлт, Ерөнхий төлөвлөгөөний газар
- Нийслэлийн Онцгой байдлын газар
- Нийслэлийн Газрын алба
- Нийслэлийн Авто замын хөгжлийн газар
- “Улаанбаатар хотын Шуурхай удирдлага зохицуулалтын төв” ОНӨААТҮГ
- “Геодези, Усны барилга байгууламжийн газар” ОНӨААТҮГ
- Баянзүрх дүүрэг
- Баянгол дүүрэг
- Сонгинохайрхан дүүрэг
- Сүхбаатар дүүрэг
- Чингэлтэй дүүрэг
- Хан-Уул дүүрэг

Дөрөв. Үзлэг шалгалтын чиглэл.

Улаанбаатар хотын Зам талбайн борооны ус зайлуулах инженерийн шугам сүлжээ, үерийн ус өнгөрүүлэх далан сувгийн ашиглалтын өнөөгийн байдалд үнэлэлт дүгнэлт гаргах,

Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 102 дугаар тогтоолын дагуу Улаанбаатар хотын үерийн хамгаалалтын барилга байгууламж, борооны болон хөрсний ус зайлуулах шугамын хамгаалалтын зурвас, засвар үйлчилгээний журмын хэрэгжилтийн биелэлт,

Улаанбаатар хотыг 2019 оны хаврын шар усны үерийг өнгөрүүлэх инженерийн шугам сүлжээний бэлэн байдлыг хангуулах, ус зайлуулах системийг зайлшгүй засварлах, цэвэрлэгээ үйлчилгээ хийх, авто замын гаргалгаа нээх байршлуудын судалгааг гаргаж холбогдох арга хэмжээний санал боловсруулж танилцуулах

Тав. Үзлэгийн дүнг тайлагнах.

Ажлын хэсгийн хийсэн үзлэг шалгалтын тайлан, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний танилцуулга хийж, зөвлөмж гаргах

Зургаа. Үзлэгийн шалгалтын зардал.

- Ажлын хэсгийн хийсэн гишүүдийн үзлэг шалгалтад шаардагдах 3 группийн 4 машины 3-ийг нь "Геодези, Усны барилга байгууламжийн газар" ОНӨААТҮГ, 1 машиныг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба хариуцна.